



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 9 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

IX.34. “ХЭЛЭЛЦСЭН нь: “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн түрээсийн орлогын тухай.

ТЭМДЭГЛЭСЭН нь:

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани нь санхүүгийн хүндрэлтэй нөхцөлд байгаа тул төрийн өөрийн өмчийн байрны 2024 оны түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэлгүй бүхэлд нь тус компанид үлдээх нь зүйтэй гэж үзэв.

Мөн компанийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлж танилцуулахыг тус компанийн удирдлагад даалгав” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

